



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2015 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Инновацийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1. дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн салбарт инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэд хөтөлбөр, ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллахыг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ч.Цогтбаяр/, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /С.Мөнхнасан/-т даалгасугай

3. Хөтөлбөрийн явц, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Зулзүсэм/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбарын их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог ханган ажиллахыг дэд сайд /Х.Ержан/-д даалгасугай.

САЙД



Н ТӨМӨРХҮҮ

Зам, тээврийн сайдын 2015 оны 06.  
дугаар сарын 24 ний өдрийн 177.  
дугаар тушаалын хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ИННОВАЦИЙН  
ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР  
/2015-2020/

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Зам, тээврийн салбарын (цаашид “салбар” гэх) шинжлэх ухаан, технологийн хөгжлийг шинэ түвшинд гаргах, оюуны өмчийг баялаг болгох, технологийн агууламжтай үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйлсийн нэг нь инновацийн тогтолцоог хөгжүүлэх явдал юм.
- 1.2. Инновацийн тогтолцоог хөгжүүлэх нь хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхээс гадна өнөөгийн нийгмийн өмнө тулгарч буй томоохон асуудал болох уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, тогтвортой хөгжилд хүргэх гол арга зам мөн.
- 1.3. Салбарын эрэлт хэрэгцээг хангасан, дэвшилтэт, шалгарсан технологийг нэвтрүүлэх, үүгээр дамжуулан инновацийн чадавхыг бий болгох, өөрийн орны онцлогт тохирсон, үр ашигтай технологийг хөгжүүлэх замаар өрсөлдөөнд суурилсан инновацийн үйл ажиллагааг нэн түрүүнд дэмжинэ.
- 1.4. Улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг, инновацийн үйл ажиллагааны төрийн зохицуулалтын үндсэн чиглэлийг тодорхойлсон боловсрол, шинжлэх ухаан, аж үйлдвэрийн талаарх төрийн бодлоготой уялдсан байна.

ХОЁР. Хөтөлбөрийн баримтлах бодлогын зорилго ба зарчмууд

- 2.1. Инновацийн хөтөлбөрийн бодлогын зорилго
  - 2.1.1. Салбарт инновацийн соёл, хандлага, орчныг төлөвшүүлэх;
  - 2.1.2. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын зам, тээврийн чиглэлээр хийсэн оюуны өмчийг баялаг болгох;
  - 2.1.3. Энтрепренер үйл ажиллагаа, технологи дамжуулалтыг дэмжих замаар салбарын шинжлэх ухаан технологийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
  - 2.1.4. Экспортын баримжаатай, оюуны багтаамж өндөртэй брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гарааны компаниудыг төрүүлэх, бойжуулах;
  - 2.1.5. Инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх;
  - 2.1.6. Үндэсний аюулгүй байдал, улс орны тогтвортой хөгжлийг хангах;
- 2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах бодлогын зарчим

- 2.2.1. шинжлэх ухаан, технологи, инновацийг салбарын хөгжлийг тодорхойлогч хүчин зүйл болгон хөгжүүлэх;
- 2.2.2. нөөцийг инновацийн тэргүүлэх чиглэлд төвлөрүүлэх;
- 2.2.3. тогтвортой хөгжлийг хангах;
- 2.2.4. үндэсний аюулгүй байдал, эрх ашигт нийцсэн байх;
- 2.2.5. үр ашигтай, бүтээмжтэй байх;
- 2.2.6. Төрийн дэмжлэгийг ил тод, тэгш хүртээх;
- 2.2.7. байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт, шалгарсан техник, технологи нэвтрүүлэх, бий болгох;

#### ГУРАВ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах бодлогын чиглэл

- 3.1. Салбарын инновацийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх;
- 3.2. Мэдлэг бий болгох салбарын үр ашгийг сайжруулах замаар хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах, бүрдүүлэх;
- 3.3. Инновацийн үйл ажиллагааг дэмжих чадавхи бүхий дэд бүтцийг байгуулах;
- 3.4. Инновацийн үйл ажиллагааг дэмжих санхүүгийн механизмыг боловсронгуй болгох, инновацийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;
- 3.5. Инновацийн хүрээнд олон улсын хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх;

#### ДӨРӨВ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

- 4.1. Инновацийн тогтолцоох бүрдүүлэх арга зам
  - 4.1.1. Инновацийг нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд хөгжүүлэх бололцоог бий болгох, энэхүү үйл ажиллагаан дахь саад бэрхшээлийг арилгах, татварын хөнгөлөлт болон бусад механизмаар дэмжих, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;
  - 4.1.2. Шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн тогтвортой хамтын ажиллагаа, хамтарсан судалгааны ажлыг дэмжин урамшуулах, эдийн засгийн хөшүүргийг бий болгох;
  - 4.1.3. Дээд боловсрол, шинжлэх ухаан үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн үр ашигтай интеграцийг хангах, хөгжлийн төлөөх түншлэлийг дэмжих замаар салбарын инновацийн тогтолцоог бий болгох;
  - 4.1.4. Оюуны өмч, технологи дамжуулалт, лиценз ашиглалт, төсөл хэрэгжүүлэх зэрэг асуудалтай холбоотой үйл ажиллагааг сайжруулах, чадавхжуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх;
  - 4.1.5. Холбогдох хууль эрх зүйн орчин, бодлогыг боловсронгуй болгох;
  - 4.1.6. Төслийн өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын тогтолцоог боловсронгуй болгох;
  - 4.1.7. Дэвшилтэт, шалгарсан технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйл ажиллагаанд төрөөс татвар, санхүүгийн дэмжлэг үзүүлэх байдлаар хувийн секторын өсөлтийг дэмжих;
- 4.2. Хүний нөөцийг чадавхжуулах арга зам
  - 4.2.1. Мэргэжлийн давтан сургалт, мэргэшүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох замаар бүтээлч сэтгэлгээ, энтрепренер хандлага бүхий хүний нөөцийг төлөвшүүлэн бий болгох;

4.2.2. Дэвшилтэт, шалгарсан технологийг нэвтрүүлэх, дамжуулах, нутагшуулах, уламжлалт шинжлэх ухаан, технологийн өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх замаар хүний нөөцийг хөгжүүлэх;

#### 4.3 Инновацийн дэд бүтэц бий болгох арга зам

4.3.1. Инновацийн өнөөгийн дэд бүтцийг бэхжүүлэх, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн толгойлох салбарын лабораторийг бий болгох;

4.3.2. Байгууллага дундын шинжилгээний төв, нээлттэй лаборатори, технологийн инкубаторыг байгуулах, бэхжүүлэх;

4.3.3. Бизнес инкубатор, технологи дамжуулах төвийг байгуулах, чадавхжуулах;

4.3.4. Инновацийн тэргүүлэх чиглэлээр судалгаа эрдэм шинжилгээний төв байгуулахад аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх;

#### 4.4 Инновацийн үйл ажиллагааны санхүүжилт

4.4.1. Инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн байгууллагын болон салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусган хэрэгжүүлэх;

4.4.2. Салбарын болон орон нутгийн сан, түүнчлэн зээлийн батлан даалтын болон хөгжлийн сангийн үйл ажиллагааг технологийн гарааны компанийг дэмжихэд чиглүүлэх байдлаар гарааны бизнесийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

4.4.3. Инновацийн төслийг дэмжих зорилго бүхий төр болон хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн механизмийг бий болгох;

4.4.4. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, эрсдэлийн хөрөнгийг бүрдүүлэх, зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах, санхүүгийн эрсдэлийг бууруулах зэрэг арга хэрэгслийг инновацийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

4.4.5. Инновацийн үйл ажиллагааг төрийн худалдан авалтаар дэмжих;

4.4.6. Салбарын эрдэм шинжилгээ, дээд боловсролын байгууллагын инновацийн үйл ажиллагааг дэмжих, бизнесийн (либералчлах) эрх чөлөөг нэмэгдүүлэх;

4.4.7. Оюуны багтаамж ихтэй, өндөр технологийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулагчдыг дэмжих;

#### 4.5 Салбарын инновацийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох

4.5.1. Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулахад чиглэсэн, Зам, тээврийн салбарын өндөр технологийн үйлдвэрлэлийг салбарын инновацийн тэргүүлэх чиглэлд хамааруулна.

### **ТАВ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат**

5.1. 2015-2018 эхний үе.

5.2. 2018-2020 хоёрдугаар үе гэсэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

### **ЗУРГАА. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн**

- 6.1. Энтрепренерүүд бий болж эхэлсэн байна.
- 6.2. Инновацийн үйл ажиллагаанаас орох орлого нэмэгдсэн байна.
- 6.3. Өндөр технологид суурилсан үйлдвэрлэлийн хэмжээ өсч, үндэсний өвөрмөц тэргүүний технологийн үндсэн дээр суурилсан брэнд бүтээгдэхүүн бий болсон байна.

**ДОЛОО.** Удирдлага, зохион байгуулалт, хяналт, шинжилгээ, үнэлгээ

- 7.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зам, тээврийн салбарын байгууллага бүр дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллана.
- 7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг инновацийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 7.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат бүрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

-oOo-